



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 19/13

Жавхлант

Байгууллагын үнэлгээний
баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 03 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, хянаж баталгаажуулах, мэдээлэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний багийн

дарга: Т.Эрдэнэцэцэг

Санхүү албаны дарга

Нарийн бичгийн

дарга: Н.Мөнхгэрэл

Архив, бичиг хэргийн эрхлэгч

Гишүүд: Э.Жагдаг

Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

2.Хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээгээр "Маш сайн" үнэлгээний ангилалд хамаарах албан хаагчдыг үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй, хэвийн үнэлгээний ангилалд хамаарах албан хаагчдыг үндсэн цалингийн 25 хүртэлх хувиар тус тус урамшуулахаар тогтоосугай.

3.Үнэлгээний багийн гишүүдийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг батлагдсан аргачлалын дагуу үнэлж, хянан баталгаажуулж, мэдээлэхийг үнэлгээний баг (Т.Эрдэнэцэцэг)-т даалгасугай.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.ШАРАВГАВАА

D:Tamgiin darga /tushaal-2025/